

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2026/003/НА-СТА-ТӨҮГ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
ШТН ТӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1 Залруулсан алдаа	8
5.2 Залруулаагүй алдаа	8
5.2.2 Албан шаардлага	8
5.2.3 Зөвлөмж	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЗДХЯ	Зам Тээвэр Хөгжлийн Яам
ЗТХТ	Зам тээвэр хөгжлийн төв
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.13 № 01/241
танай _____-ны № _____-т

“ШТН” ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ ДЭД
ХУРАНДАА Б.МЯГМАРДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа “ШТН” ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх оны аудитаар үр ашигтай ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй, тайлант онд борлуулалтын орлого 32%-иар тасарч, үндсэн үйл ажиллагааны 51,697.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төр, хувийн хэвшилтэй хамтран ажиллах төслийн хүрээнд “ШТН” ТӨААТҮГ нь “Лаймстоун Минералс” ХХК-тай 5 жилийн хугацаатай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан ба 2025 онд 3,185.9 тн шохойн чулуу олборлосон байна.

Аудитын гол асуудал

Тайланд онд салбар замын түрээсийн орлого 210,900.0 мянган төгрөг, бүтээгдэхүүн борлуулалтын орлого 179,428.8 мянган төгрөг, Шүүхийн шийдвэр

4126020473

гүйцэтгэх Ерөнхий газраас 17,850.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 492,847.9 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95,0 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	79,681.70	430,126.26
1.1.02	Дансны авлага	0.00	35,340,000.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	265,909.09	0.00
1.1.04	Бусад авлага	3,000,000.00	3,032,641.53
1.1.06	Бараа материал	684,570,866.02	766,306,764.96
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	70,740,000.00	70,740,000.00
1.1.11	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	758,656,456.81	875,834,899.34
1.2.01	Үндсэн хөрөнгө	838,104,160.53	1,049,836,133.38
1.2.02	Биет бус хөрөнгө	1,629,253,600.00	1,629,253,600.00
1.2.10	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,467,357,760.53	2,679,089,733.38
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,226,014,217.34	3,554,939,266.13
2.1.1.01	Дансны өглөг	44,251,916.90	14,240,700.00
2.1.1.02	Цалингийн өглөг	232,813.20	0.00
2.1.1.03	Татварын өр	58,805,114.11	65,265,230.10
2.1.1.04	НДШ - ийн өглөг	31,993.74	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	28,560,000.00	4,560,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	6,666,350.00	13,725,363.00
2.1.1.13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	138,548,187.95	97,791,293.10
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	138,548,187.95	97,791,293.10
2.3.01	Өмч: - төрийн	2,093,163,566.01	2,093,163,566.01
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	181,724,011.25	180,878,427.41
2.3.09	Хуримтлагдсан ашиг	812,578,452.13	1,183,105,979.61
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	363,081,360.64
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	812,578,452.13	820,024,618.97
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,087,466,029.39	3,457,147,973.03
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,226,014,217.34	3,554,939,266.13

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО(цэвэр)	304,893,227.26	302,313,424.82
2	БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	224,301,186.22	175,389,704.03
3	НИЙТ АШИГ (алдагдал)	80,592,041.04	126,923,720.79
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	126,887,701.55	191,934,374.08
8.1	ОРЛОГЫН ДҮН	126,887,701.55	191,934,374.08
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	313,167,948.02	317,287,982.31
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	ЗАРДЛЫН ДҮН	313,167,948.02	317,287,982.31
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	179,139,663.36	361,666,796.00
17.1	ОЛЗ, ГАРЗЫН ДҮН	179,139,663.36	361,666,796.00
18	ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ(алдагдал)	73,451,457.93	363,236,908.56
19	Орлогын татварын зардал	0.00	155,547.92
20	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (алдагдал)	73,451,457.93	363,081,360.64
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (алдагдал)	73,451,457.93	363,081,360.64

23	Бусад дэлгэрэнгүй орлого		0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)		0.00	0.00
24	ОРЛОГЫН НИЙТ ДҮН		0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,156,313,966.01	181,724,011.25	719,126,994.20	2,057,164,971.46
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	936,849,600.00	-	20,000,000.00	956,849,600.00
03	Залруулсан үлдэгдэл	2,093,163,566.01	181,724,011.25	739,126,994.20	3,014,014,571.46
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	73,451,457.93	73,451,457.93
05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	2,093,163,566.01	181,724,011.25	812,578,452.13	3,087,466,029.39
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	7,446,166.84	7,446,166.84
11	Залруулсан үлдэгдэл	2,093,163,566.01	181,724,011.25	820,024,618.97	3,094,912,196.23
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	363,081,360.64	363,081,360.64
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	(845,583.84)	-	(845,583.84)
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	2,093,163,566.01	180,878,427.41	1,183,105,979.61	3,457,147,973.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	437,565,347.00	459,000,800.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	341,597,250.00	230,250,800.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	95,968,097.00	228,750,000.00
1.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	432,063,609.21	458,650,355.44
1.2.1	Ажиллагчдад төлсөн	275,577,207.17	280,455,300.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,671,905.82	5,219,904.87
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	16,556,470.00	21,910,272.00

1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	910,550.00	499,800.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	64,870,320.00	75,808,960.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	17,818,174.22	45,818,033.74
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	501,759.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	50,658,982.00	28,436,325.00
1.3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	5,501,737.79	350,444.56
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
2.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	-	-
2.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	561,000.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	561,000.00	-
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(561,000.00)	-
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
3.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	-	-
3.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	15,000,000.00	-
3.2.5	Бусад	15,000,000.00	-
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(15,000,000.00)	-
4	БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(10,059,262.21)	350,444.56
5	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	10,138,943.91	79,681.70
6	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	79,681.70	430,126.26

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Бүтээгдэхүүний төрөл	Үйлдвэрлэл			Борлуулалт		
	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1 Шохойн чулуу	63,000.0	90,000.0	143%	131,250.0	97,030.1	74%
2 Эрдэс нунтаг	22,685.0	2,135.5	9%	37,800.0	3,233.0	9%
3 Замасканы бэлдэц	79,765.0	91,689.8	115%	192,000.0	151,926.0	79%
4 Мозайкан чулуу	73,920.0	108,905.5	147%	81,000.0	8,916.6	11%
5 Цагаан замаска	18,780.0	31,819.1	169%	46,200.0	68,986.0	149%
НИЙТ ДҮН	258,150.0	324,549.9	126%	488,250.0	330,091.7	68%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 8,060.9 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 8,060.9 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа.Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5 мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Мөнгөн гүйлгээний тайлангаар 4,400.0 мянган төгрөгийн орлого болон 3,295.1 мянган төгрөгийн зардлыг дутуу тайлагнасан байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. НДШ-ийн тайланг ажилтан албан хаагчдад олгосон цалинтай тулгаж үзэхэд 2025 онд 365.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Уг тайлагналын зөрүүнээс үүдэн авлагын дүн буруу илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д "Харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийхээс гадна төрийн эрх бүхий байгууллага нь энэхүү цахим санд баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг ашиглана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3.2 Залруулаагүй алдаа

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 51,697.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 48,185.9 мянган төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 51,697.1 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

3.2.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

3.2.2 Албан шаардлага

1. Өмнөх оны аудитаар үр ашигтай ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй, тайлант онд борлуулалтын орлого 32 хувиар тасарч, үндсэн үйл ажиллагааны 51,697.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3.2.3 Зөвлөмж

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ШТН ТӨААТҮГ-ын захирлын 2025.01.22-ны А/16 дугаар тушаалаар баталсан Дотоод хяналт, шалгалт явуулах ажлын хэсэг нь тайлант онд төлөвлөгөөний дагуу дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна. Энэ нь Аж ахуй нэгж байгууллагын дотоод хяналт шалгалт явуулах тухай Засгийн газрын 311 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах, зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	3	8,060.9	2	7,695.1	1	365.8	3	8,060.9				
Дүн	3	8,060.9	2	7,695.1	1	365.8	3	8,060.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр ашиггүй ажилласан.	1	51,697.1			1	51,697.1		
Дотоод хяналт шалгалт хийгдээгүй.	1	-					1	-
Дүн	3	51,697.1			1	51,697.1	1	-